



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/269

Булган сум

### Сургалт, зөвлөгөөний зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд нийгмийн салбарт мөрдөгдөж буй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал, хүүхэд хамгааллын хуулийг сурталчлах, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах нэгдсэн сургалт, зөвлөгөөний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Сургалт, зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах 2,570,000 (Хоёр сая таван зуун далан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр хэрэгжүүлэх зардлын Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хорооны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
01 дүгээр сарын 23-ний өдрийн А/269 дугаар  
захирамжийн хавсралт

НЭГДСЭН СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

Д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Хоолны зардал	90	18.000	1.620.000
2	Их үдийн цай	90	5.000	450.000
3	"Аха" тэмцээний шагнал	1	100.000	100.000
4	ХАБЭА-н сургагч багшийн зардал	2 цаг	200.000	400.000
5	Нийт			2.570.000